



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 534

Улаанбаатар хот

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит
үйлдвэрийн газрын дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэмд дор дурдсаны дагуу өөрчлөлт оруулсугай. Үүнд:

Зургаа. Үйлдвэрийн газрын удирдлага

6.2.Үйлдвэрийн газар нь Захиргаа, санхүү хариуцсан, Ачаа тээвэр хариуцсан, Мэдээлэл, зорчигч тээвэр хариуцсан болон Техник хариуцсан 4 дэд захиралтай байна.

6.10.2.Дэд захирлуудыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцсөний дагуу захирал томилж, өөрчилнө.

6.15.Захирлын эзгүйд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас эрх олгосноор Захиргаа, санхүү хариуцсан дэд захирал орлон ажиллана.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 147 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ